

## ОРГАНИК МОНГОЛ ХӨТӨЛБӨРИЙН ЗЭЭЛИЙН ЖУРАМ

(Шинэчилсэн найруулга)

### НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Бүс нутаг, аймаг орон нутгийнхаа онцлогыг илэрхийлж чадахуйц ОРГАНИК МОНГОЛ БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН-үүдийг бий болгох, сонгон шалгаруулж хөгжүүлэх, дэмжих, байгаль орчинд ээлтэй ногоон бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх, санхүүгийн туслалцаа авах боломжоор хомс аж ахуйн нэгж, байгуулага иргэдэд санхүүжилт олгох замаар органик хэрэглээ, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангахад хувь нэмрээ оруулна.
- 1.2. Органик Монгол хөтөлбөрийн зээлийн үйл ажиллагаанд Монгол улсын иргэний хууль, банкны тухай хууль болон энэхүү төслөөс зээл олгож байгаа ХасБанк, Капитал банкны зээлийн үйл ажиллагааны ерөнхий журам, тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад журам, зааврыг мөрдөж ажиллана.

### ХОЁРДУГААР ЗҮЙЛ: ТӨСӨЛД ТАВИХ ШААРДЛАГА

- 2.1 Хөрөнгө, оруулалт санхүүжилтийн тооцоо судалгаа үнэн зөв хийсэн, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, хэрэгжих боломжтой, мөнгөн урсгалын төсөөлөл, үр ашгийн тооцоогоор зээл, хүүний төлбөрийг бүрэн төлөх боломжтой байх;
- 2.2 Санхүүжигдэх төсөл нь байгалийн цэвэр хөдөө аж, ахуйн гаралтай хүнсний болон бусад төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлтэй байх;
- 2.3 Төслийн үйл ажиллагаа нь нэг жилийн хугацаанд багтан үр ашгаа өгч чадахуйц байх.
- 2.4 Санал болгож буй төсөлд дараах мэдээлэл заавал байна. Үүнд:
  - 2.4.1 Төслийн үндэслэл, зорилгыг оновчтой тодорхойлсон;
  - 2.4.2 Хэрэгжүүлэх арга зөв тодорхойлсон;
  - 2.4.3 Төсөл хэрэгжих нөхцлөө /жишээ нь: газрын боловсруулалт, нөөцийн хуваарилалт, ажлын байр, техник, тоног төхөөрөмжийн нөхцөл, шаардлагыг зөв тодорхойлсон, ажиллах хүчний асуудлыг бүрэн шийдсэн, тодорхойлсон, бэлтгэсэн, төлөвлөсөн байх;
  - 2.4.4 Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулах хэлбэр, арга зам, төлөвлөгөөг боловсруулсан байх;

## ГУРАВ: САНХҮҮЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН ШААРДЛАГА, НӨХЦӨЛ

- 3.1. Зээлийн үйл ажиллагаанд баримтлах бодлого
  - 3.1.1. Төслийн зээлийг бүх орон нутагт ХасБанк, Капитал банкны салбар, тооцооны төвөөр дамжуулан хэрэгжүүлнэ;
  - 3.1.2. Хөтөлбөрөөс олгох зээлд төслийн үйл ажиллагаа, ашигт ажиллагаанаас хамааран тодорхой хэмжээний барьцаа хөрөнгө барьцаалж олгоно.
  - 3.1.3. Суманд төмс, хүнсний ногоо тариалж байгаа иргэдэд хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ХасБанктай Франчайзийн гэрээгээр хамтран ажилладаг хадгаламж, зээлийн хоршоодоор дамжуулж санхүүгийн үйлчилгээг хүргэнэ.
  - 3.1.4. Төсөлд хамрагдаж байгаа хуулийн этгээд, иргэдийн явуулж байгаа үйл ажиллагаанаас хамааран зээлийн хугацаа 2 жил хүртэл, зээлийн дээд хэмжээ 50 хүртэл сая төгрөг байна.
  - 3.1.5. Төслийн зээлийг тариалан эрхлэгч нараас гадна нэмүү өртөг бий болгогч бүлэг, хувь хүн, иргэдэд олгоно.
- 3.2. Зээл хүсэгч нь дараах шаардлагыг хангасан байна.
  - 3.2.1. Хэрэгжүүлэхээр санал болгож буй төслийн хүрээнд шаардлагатай бүх тооцоог хийж, бэлдсэн байх;
  - 3.2.2. Төсөл хэрэгжүүлэх иргэн нь хуулийн этгээд, төсвийн байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлдэггүй байх;
  - 3.2.3. Бусад хуулийн этгээд, иргэнд өр төлбөргүй;
  - 3.2.4. Насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай иргэн.
- 3.3. Зээлийн ерөнхий нөхцөл:
  - 3.3.1. Зээлийн хэмжээ:
    - 3.3.1.1. Хөдөө аж ахуйн гаралтай органик бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг иргэд, хуулийн этгээд, хоршоодод 20,0 сая төгрөг хүртэл,
    - 3.3.1.2. Орон нутгийн “Органик Монгол” брэнд бүтээгдэхүүнд 50,0 сая төгрөг хүртэл
  - 3.3.2. Зээлийн хугацаа:

- 3.3.2.1. Хөдөө аж ахуйн гаралтай органик бүтээгдэхүүний үйлдвэрлэх төсөлд 3-12 сар,
- 3.3.2.2. Нэмүү өртөг бий болгож байгаа иргэд, хуулийн этгээд хоршоодод 3-24 сар
- 3.3.3. Зээлийн хүү:
  - 3.3.3.1. 30 хоногт 1.0 %
- 3.3.4. Зээлийн үйлчилгээний хураамж, шимтгэл, бусад:
  - 3.3.4.1. Хөтөлбөрийн зээл олгож байгаа банкны нөхцөлийг дагаж мөрдөнө.
- 3.3.5. Зээлийн барьцаа:
  - 3.3.5.1. Хөтөлбөрийн зээл олгож байгаа банкны журам, зааврыг дагаж мөрдөнө.
- 3.3.6. Даатгалын нөхцөл:
  - 3.3.6.1. ХасБанкаар дамжуулан олгож байгаа ОМ хөтөлбөрийн зээлийг Тэнгэр даатгалийн компаний бичил зээлийн даатгалд сайн дурын үндсэн дээр хамруулна.
  - 3.3.6.1. Капитал банкаар дамжуулан олгож байгаа ОМ хөтөлбөрийн зээлийг “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ын даатгалд сайн дурын үндсэн дээр хамруулна.

#### ДӨРӨВ: ТӨСЛИЙН ШАЛГАРУУЛАЛТ ХИЙХ, ЗЭЭЛ ОЛГОХ ҮЙЛ ЯВЦ

- 4.1. Хөтөлбөрт хамрагдахыг хүссэн хөдөө, орон нутгийн иргэд тухайн өөрийн оршин суугаа газар нутагт байрлах ХАҮТанхимын салбар, “Петровис” ХХК, Капитал банк, ХасБанкны салбар, тооцооны төвөөс анкет авч бөглөн, өөрийн боловсруулсан төсөлтэй хамт эргэн тухайн газраа өгч бүртгүүлэн эхний шалгаруулалтанд орно.
- 4.2. УБ хот болон хот орчмын суурин газруудаас оролцохыг хүссэн иргэд “Петровис” ХХК-ийн төв байр /спортын төв ордны баруун талд хуучнаар “НИК” ХК ийн байр/, Капитал банкны төв байр /Тэнгис кино театрын баруун урд, Бишрэлт худалдааны төвийн хажууд/, Хасбанкны төв байр /Сүхбаатарын талбайн зүүн талд, соёлын төвийн ард/-ны нэг давхарт ресепшинд бүртгүүлэн анкет авч бөглөн, боловсруулсан төслөө өгнө.
- 4.3. Хөтөлбөрт хамруулах зээлийг хугацааны хувьд 2 шаттай шалгаруулна. 1-р шат 3-4 сард, 2-р үе шат 5-р сар болон түүнээс хойш үргэлжилнэ.

- 4.4. 1-р шатанд байгалийн цэвэр эрүүл хүнс үйлдвэрлэх төсөл буюу ХАА-н гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 2-р шатанд ХАА-аас гадна тухайн аймаг, орон нутгийн онцлогийг илэрхийлсэн, байгаль орчиндоо сөрөг нөлөөгүй үйлдвэрлэлийн шат дамжлагыг дамжин хийгдсэн, ногоон бүтээгдэхүүний төслийг сонгон шалгаруулна.
- 4.5. Төслүүдийг хүлээн авч АНКЕТ болон төсөл дээр үндэслэн боломжтой гэж үзсэн төсөл боловсруулагч иргэдийг ЯРИЛЦЛАГА–д оруулна.
- 4.6. Ярилцлагын дараа ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР ДЭЭР очиж БОДИТ БАЙДЛЫН ХАРЬЦУУЛСАН ҮНЭЛГЭЭ хийн орон нутаг дахь салбар, нэгжийн төлөөлийн ажлын хэсэг дүгнэлт гарган сонгон шалгаруулалт явуулна. Шалгарсан төслийг Капитал банк, ХасБанкны салбар, тооцооны төвд хүргүүлэх бөгөөд зээлдэгчийн зээлийн судалгааг банкны шалгуурын дагуу судалж зээл олгох боломжтой иргэдтэй банкны зээлийн гэрээ байгуулан зээл олгоно.
- 4.7. Төслийн сонгон шалгаруулалт хийх үйл явцад анкет болон төслийг 3-р сард хүлээн авч 4-р сараас эхлэн зээл олгож эхэлнэ. Шаардлагатай тохиолдолд төслийн эзэнтэй тусгайлан урьдчилан тохиролцож ярилцлага хийж болно.
- 4.8. Зөвлөгөө өгөх шаардлагатай хүсэлт гаргасан төсөлд МҮХАУТанхимын зүгээс бэлэн төслийн загвар өгөх, санхүүгийн төлөвлөлт хийхэд зөвлөмж туслалцаа үзүүлэх зэргээр дэмжлэг үзүүлнэ.
- 4.9. Төслийг хүлээн авах хугацаа, шаардлагын дагуу хүсэлт гаргасан хүн нэг бүр нь ижил боломжоор хангагдана.
- 4.10. Шалгаруулалтын болон төслийн хэрэгжилтийн шатанд хөтөлбөрийн зүгээс товч видео бичлэг хийх, болон зураг авалт хийж болно.
- 4.11. Эдгээр бичлэг зураг материалыг төсөлд хамрагдахыг хүссэн иргэдийн эрх ашгийг хөндөхгүйгээр хөтөлбөрийн талаар гарах нэвтрүүлэг, мэдээ мэдээлэлд ашиглаж болно.
- 4.12. Шалгарсан төсөлд шаардлагатай тохиолдолд анхан шатны болон нарийн мэргэжлийн мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулж төслийг амжилттай хэрэгжих нөхцөлийг хангах зэргээр хөтөлбөрийн зүгээс дэмжиж ажиллана.
- 4.13. Шалгарсан төсөлд олгох зээлийг зээлдэгчийн хүссэн хугацаанд олгон, зээлийн хүү үндсэн төлбөрийг зээлдэгчийн хүсэлт дээр үндэслэн уян хатан тогтооно.
- 4.14. Хөтөлбөрийн явцад төсөл нь шалгарсан иргэдийн төслийн хэрэгжилтэнд хөтөлбөрийн зүгээс байнга хяналт тавин ажиллах ба төслийн үр дүнд бий болсон бүтээгдэхүүний борлуулалтыг “Бишрэлт холдинг” компанийн “Бишрэлт” худалдааны төв, “Well Mart” худалдааны төв болон “МАКС” группын сүлжээ дэлгүүрээр дамжуулан борлуулах хэлбэрээр дэмжих, үзэсгэлэн арга хэмжээнд

оролцуулах, сурталчилах, маркетингийн тал дээр анхааран зах зээлд таниулах зэргээр хөтөлбөрийн зүгээс дэмжиж ажиллана.

\*\*\*\*\*